



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑1 оны 08 сарын ᠑᠐ өдөр

Дугаар А/᠑᠑2

Мандалговь

Хөдөө аж ахуйн салбар болон төв,  
суурин газрын 2021-2022 оны өвөлжилт,  
хаваржилтын бэлтгэл хангах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурин газрын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 18-ний өдрийн 03 тоот албан даалгавар, 2021-2022 оны аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 20-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 25-ний дотор хангаж, тайланг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоол, албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажил зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих, шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж, дүн мэдээг 10 дугаар сарын 26-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)- т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210086

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 10-ний өдрийн 1/31 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)
- Нарийн бичгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- Гишүүд:
- О.Мөнхзул (Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
  - С.Бат-Оргил (Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч)
  - М.Адъяабаатар (Онцгой байдлын газрын дарга)
  - Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
  - Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын дарга)
  - Б.Золжаргал (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
  - Ц.Уранбямба (Боловсрол, соёл, урлагийн газрын даргын түр орлон гүйцэтгэгч)
  - О.Бархүү ("Дундговь-Ус" ОНӨҮГ-ын захирал)
  - Ц.Хүрэлбаатар (Автотээврийн төвийн дарга)
  - Д.Очбадрах (Сайнцагаан сумын Хот тохижуулах газрын дарга)
  - С.Намжилцэрэн (Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын дарга)
  - Б.Мягмарсүрэн (Багануур зүүн өмнөд бүсийн ТӨХК-ийн Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга)
  - Х.Баяртогтох ("Дундговь авто зам" ХХК-ийн захирал)
  - Б.Бямбасүрэн (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)